



**ХЭНТИЙ АЙМГИЙН
ДЭЛГЭРХААН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 02 сарын 10 өдөр

Дугаар 4/16

Дэлгэрхаан сум

Захирамжийн заалтад өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Захиргааны Ерөнхий хуулийн 38 дугаар зүйлийн 38.1, 45 дугаар зүйлийн 45.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Засаг даргын Тамгын газрын санхүү албаны дарга байсан О.Ууганбаярын 2021 оны 10 дугаар сарын 14-ний өдөр ирүүлсэн өргөдөл, хүсэлт нь эрүүл мэндийн хүндэтгэн үзэх шалтгаанаар байсан учир ажлаас чөлөөлсөн хуулийн заалтыг дор дурдсан заалтаар өөрчлөлт оруулсугай.

2.Сумын Засаг даргын “Ажлаас чөлөөлөх тухай” 2021 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн Б/21 дугаар захирамжаар Засаг даргын Тамгын газрын санхүү албаны дарга О.Ууганбаярыг чөлөөлсөн Төрийн албаны тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.2.4 дэх заалтыг 46 дугаар зүйлийн 46.1.1 дэх заалт болгон өөрчилсүгэй.

3.Энэхүү захирамжийг Төрийн албаны салбар зөвлөлд өргөдөл, албан хүсэлтийн хамт хүргэж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Д.Урангоо)-д даалгасугай.

ДАРГА



Б.ЭНХАМГАЛАН

